



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/482

Булган сум

### Нийлүүлэгчтэй гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Хог хаягдлыг зайлуулах зориулалтаар экскаватор авах (Сайхан сум) нийлүүлэгчээр шалгарсан “Би Би Кэй Эйч” ХХК-тай 179,800,000 (нэг зуун далан есөн сая найман зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-т олгосугай.

2. Нийлүүлж буй бараанд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн аван данс бүртгэлд бүртгэж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Сайхан сумын Засаг дарга (М.Ганболд)-д үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан барааг холбогдох хууль, журам, стандарт, техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлж хүлээлгэн өгөхийг “Би Би Кэй Эйч” ХХК-ийн гүйцэтгэх захирал (С.Нямдорж)-д даалгасугай.

4. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг хавсралтаар баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус барааны санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Э.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА


Д.ПҮРЭВ-ОЧИР



Сугар Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010659

Аймгийн Засаг даргын 2025 оны  
07 дугаар сарын 07-ны/ний өдрийн  
А/482 дугаар захирамжийн хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Бараа нийлүүлэх хугацаа	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор	А.Гантөмөр
2	Баталгаат хугацаа	12 сар	М.Ганболд
3	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь	Э.Эрдэнэжаргал
4	Алданги	Хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Э.Эрдэнэжаргал